

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/160/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он	<table><tr><td>Тэргүүлэх аудитор:</td><td>Д.Анхбаяр</td></tr><tr><td>Утас: 90900910</td><td>Цахим хаяг:</td></tr><tr><td>Аудитын менежер:</td><td>Ж.Энхцоодол</td></tr><tr><td>Утас: 99057478</td><td>Цахим хаяг:</td></tr><tr><td>Аудитор:</td><td>З.Ганбаатар</td></tr><tr><td>Утас: 99411126</td><td>Цахим хаяг Ganbaatarz@gov.mn</td></tr></table>	Тэргүүлэх аудитор:	Д.Анхбаяр	Утас: 90900910	Цахим хаяг:	Аудитын менежер:	Ж.Энхцоодол	Утас: 99057478	Цахим хаяг:	Аудитор:	З.Ганбаатар	Утас: 99411126	Цахим хаяг Ganbaatarz@gov.mn
Тэргүүлэх аудитор:	Д.Анхбаяр												
Утас: 90900910	Цахим хаяг:												
Аудитын менежер:	Ж.Энхцоодол												
Утас: 99057478	Цахим хаяг:												
Аудитор:	З.Ганбаатар												
Утас: 99411126	Цахим хаяг Ganbaatarz@gov.mn												

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	15
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22

Аудитын гэрчилгээ

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580 <u>2020.02.27 № 102</u> танай _____ -ны № _____ т Аудитын гэрчилгээ	БУЛГАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ДАРГА Л.ГАЛБАДРАХ ТАНАА
--	---

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020710

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.1. Оршил

Булган аймгийн Мал эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Газрын дарга Л.Галбадрах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн мал эмнэлгийн газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган аймгийн мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжсэн харилцааг зохицуулахад оршино.

Булган аймгийн мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал эмнэлгийн үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- НБ Бүртгэлийн бодлого /шинээр батлагдсан/
- Байгууллагын дотоод журам /шинэчлэн батлагдсан/

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймгийн Мал эмнэлгийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Динамик программ хангамж ашигладаг байна.

Булган аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Булган аймгийн мал эмнэлгийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны

эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 565752.4 мянган төгрөгөөс тооцон 11315.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардал болох 1756826.7 мянган төгрөгөөс 2 хувь болох 35136.5 мянган төгрөгийг материаллаг байдлаар тогтоох нь зүйтэй гэж үзлээ

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган аймгийн мал эмнэлгийн газар нь 2019 онд үүсгэн байгуулагдсан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		62921.82	62921.82
Урьдчилгаа			
Бараа материал		372528957.66	372528957.66
Үндсэн хөрөнгө		270872488.41	270872488.41
Нийт хөрөнгө		643463367.89	643463367.89
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		643463367.89	643463367.89
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		643463367.89	643463367.89

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Нийгмийн даатгалын шимтгэлээ илүү бодож шилжүүлснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн, 62.9 мянган төгрөгийн байгууллагаас /ндш/ авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь шатахууны нөөц бүрдүүлсэн, МЭЕГ-аас үнэ төлбөргүй бараа материал шилжиж ирсэнтэй холбоотой байна. Оны эцэст 4277.1 мянган төгрөгийн шатахууны үлдэгдлийг бараа материалын нөөц үүсгэсэн нь дараа оны санхүүжилт ирэх хүртэл мал, амьтны гоц халдварт өвчин гарах үед албан ажлыг тасалдуулахгүй явуулах шаардлагатай холбоотойгоор нөөц бүрдүүлэн ажилласан байна.

Мал эмнэлгийн газар нь 2019 онд 01 дүгээр сарын 01-ны өдрөөс үйл ажиллагааг эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр 26382.6, үнэ төлбөргүй хүлээн авсан 248835.3 мянган төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгджээ.

Үүнд:

Төсвийн хөрөнгөөр бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1705.0, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 2369.0, багаж, техник, хэрэгслийн зардлаас 22308.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус худалдан авсан байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөд аймгийн засаг даргын нөөцөөс 10000.0, Хүнс хөдөө аж ахуйн газрын шийдвэрээр нийт 5 хөрөнгийн 238835.2 төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан нь үндсэн хөрөнгө нэмэгдэх шалтгаан болжээ.

Биет бус хөрөнгө өссөн нь Мал эмнэлгийн газар нь 2019 онд 01 дүгээр сарын 01-ны өдрөөс үйл ажиллагааг эхэлсэнтэй холбоотойгоор Төсвийн хөрөнгөөр санхүүгийн Динамик программ 880.0, Хүнс хөдөө аж ахуйн газрын шийдвэрээр үнэ төлбөргүй шилжүүлсэн Мал эмнэлгийн лабораторийн газар 26450.0, Мал эмнэлгийн хорио цээрийн газар 42526.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл тайлант онд үүсээгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Булган аймгийн Мал эмнэлгийн газар тайлант онд 1000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1107.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 110.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Шинжилгээний орлого	1000.0	1107.5	107.5	110.75
Нийт дүн	1000.0	1107.5	107.5	110.75

Булган аймгийн Мал эмнэлгийн үйл ажиллагааны орлого 107.5 мянган төгрөгөөр давсан нь шинжилгээний орлогыг дутуу төлөвлөснөөс шалтгаалж байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 684199.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 684199.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 683199.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1000,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 684199.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 667175.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1146701.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь ажиллагсдын орон тооны бүтэц дутуу байгаатайгаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Аймгийн орон нутгийн санхүүжилтээс 426661.4 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 354257.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1107.5 мянга, нийт 782025.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 696369.53 мянга, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад 77596.3 мянга, түлш шатахуунд 7360.4 мянга, нийт 781326.23 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 392.1 мянган төгрөгийг улсын/орон нутгийн/ төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 49467.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 24301.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 25256.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Шийдвэрлэсэн нь:

Аудитаар илэрсэн 25256.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шатахуун, Томилолт, Эдийн засгийн ангиллаар зарцуулсан эсэх, баримтын эмх цэгцийг тусган авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Анхаарал татахуйц бусад чухал асуудалд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийг тушаал шийдвэрийн хамт тулган шалгах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн мал эмнэлгийн газар нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Булган аймгийн Мал эмнэлгийн газар нь өмнөх аудитаар Хүнс, хөдөө аж ахуйн газарт хариатай байсан тул аудитын зөвлөмжийн бүртгэлд байхгүй болно.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган аймгийн мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган аймгийн мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Эдийн засгийн ангиллыг зөрчсөнтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 2019 оны 01 дүгээр сарын 17-ны 02/220 тоот албан бичгээр зөвшөөрсөн эдийн засгийн ангиллыг зөрчиж үндсэн хөрөнгө, бараа материалд 20.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл Буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

2. Өглөг, авлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд 0.06 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8- дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл Буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Төсвийн төлөвлөлтийг оновчтой хийж төсвийг зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй байх, авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Анхан шатны баримтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд шатахууны анхан шатны бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтыг бүрэн мөрдөөгүй байна.

3.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

4. Бараа материалын үлдэгдэл холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд төсвийн төлөвлөлтийг оновчтой хийж төсвийг зохистой удирдаагүйгээс шатахууны үлдэгдлийг их хэмжээгээр буюу 4.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

4.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэлд бараа материалын үлдэгдэл их хэмжээгээр нөөцлөгдөж дараа онд шилжиж буруу илэрхийлэгдэх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын нөөцөд байх эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлд норматив тогтоон, цаашид үлдэгдлийг бууруулах, шатахууны зарцуулалтанд лимит тогтоож зохистой хэмжээгээр нөөцөлж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

5. Бараа материалын үлдэгдэл холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант оны эхний хагас жилийн хөрөнгийн тооллого явуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх.

5.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

6. Бараа материалын үлдэгдэл холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Тайлант оны эхний хагас жилийн хөрөнгийн тооллого явуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

6.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх.

6.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	372590879.48
33	АВЛАГА	0.00	61921.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	61921.82
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	372528957.66
351	Түүхий эд материал	0.00	340993108.52
35110	Тусгай зориулалттай материал	0.00	230946226.78
35130	Эм боох материал	0.00	110046881.74
354	Хангамжийн материал	0.00	30935849.14
35410	Бичиг хэргийн материал	0.00	871750.00
35420	Аж ахуйн материал	0.00	768811.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	4277073.00
35450	Барилгын засварын материал	0.00	312000.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	24706215.14
35600	Мал амьтад	0.00	600000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	270872488.41
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
371	Урт хугацаат хадгаламж	0.00	0.00
372	Үнэт цаас	0.00	0.00
373	Урт хугацаат зээл	0.00	0.00
3731	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0.00	0.00
3732	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	270872488.41
391	Газар		
392	Биет хөрөнгө	0.00	201148488.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	154513499.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-10189371.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	119678429.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-91490929.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	281861085.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-265700824.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	61701680.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-49225080.73
393	Биет бус хөрөнгө	0.00	69723999.97
39301	Програм хангамж	0.00	880000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-132000.03

39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	68976000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	643463367.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	643463367.89
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	643463367.89
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	591374040.19
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	-52089327.70
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	643463367.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	52089327.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	643463367.89

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	2400290106.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1362833516.13
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	936172149.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	936172149.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1107549.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		935064600.13
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	426661367.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0.00	426661367.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1037456590.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	683199600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	683199600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	354256990.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	354256990.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	1736899712.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1736899712.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1709254590.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	175750972.00
210101	Үндсэн цалин	0.00	147132972.00
210102	Нэмэгдэл	0.00	21898500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	6719500.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	17968592.18
210201	Тэтгэврийн даатгал	0.00	12983025.18
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1137317.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	1416500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	215644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	2216106.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	19577636.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4602271.00
210302	Түлш, халаалт	0.00	13235275.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1740090.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	44177230.00
210401	Бичиг хэрэг	0.00	7213550.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	25879267.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2896622.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	8187791.00
2105	Нормативт зардал	0.00	411438116.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	411095216.24
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	342900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	23087247.00
210604	Урсгал засвар	0.00	23087247.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	946600.00
210702	Дотоод албан томилолт	0.00	946600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1011344197.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1010013471.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	974000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	311665.00
210807	Газрын төлбөр	0.00	45061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4963999.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	618600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	4345399.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	27645122.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	10228800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	4984900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5243900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	17416322.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17416322.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	663390393.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	19927026.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		19927026.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-19927026.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	643463367.89

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	1465225506.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	427768916.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1107549.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1107549.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1107549.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	426661367.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0.00	426661367.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1037456590.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	683199600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	683199600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	354256990.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	354256990.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	1438842906.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1438842906.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1411197784.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	175750972.00
210101	Үндсэн цалин	0.00	147132972.00
210102	Нэмэгдэл	0.00	21898500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	6719500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	18030514.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	13044947.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1137317.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	1416500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	215644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	2216106.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	19577636.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	4602271.00
210302	Түлш, халаалт	0.00	13235275.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1740090.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	46391211.00
210401	Бичиг хэрэг	0.00	8181200.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	22772910.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	3128062.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	12309039.00
2105	Нормативт зардал	0.00	6135710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	2915310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3220400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	32469777.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	9040000.00
210604	Урсгал засвар	0.00	23429777.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	946600.00
210702	Дотоод албан томилолт	0.00	946600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1111696764.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1110366038.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	974000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	311665.00
210807	Газрын төлбөр	0.00	45061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	198600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	198600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	27645122.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	10228800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	4984900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5243900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	17416322.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17416322.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	26382600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	26382600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	26382600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	26382600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	26382600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-26382600.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-52,089,327.70	-52,089,327.70
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	52,089,327.70	0.00	52,089,327.70
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	643,463,367.89	643,463,367.89
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,089,327.70	591,374,040.19	643,463,367.89

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	684199600.00	667282957.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684199600.00	667282957.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	673214700.00	657054157.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177068900.00	175750972.00
210101	Үндсэн цалин	146187500.00	147132972.00
210102	Нэмэгдэл	24161900.00	21898500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6719500.00	6719500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22133500.00	18030514.00
210201	Тэтгэврийн даатгал	15050800.00	13044947.00
210202	Тэтгэмжийн даатгал	1770700.00	1137317.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1416500.00	1416500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	354100.00	215644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3541400.00	2216106.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24869300.00	19577636.00
210301	Гэрэл, цахилгаан	5567500.00	4602271.00
210302	Түлш, халаалт	17341700.00	13235275.00
210303	Цэвэр, бохир ус	1960100.00	1740090.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49828400.00	48096211.00
210401	Бичиг хэрэг	8453700.00	8181200.00
210402	Тээвэр, шатахуун	18836500.00	22772910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8648200.00	3128062.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13890000.00	14014039.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	6419000.00	6135710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2970000.00	2915310.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3449000.00	3220400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54779000.00	54778377.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	32046000.00	31348600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	160400.00	0.00
210604	Урсгал засвар	22572600.00	23429777.00
2107	Томилолт, зочны зардал	946600.00	946600.00
210702	Дотоод албан томилолт	946600.00	946600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	336815100.00	333539537.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334896900.00	332208811.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	974000.00	974000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	594200.00	311665.00
210807	Газрын төлбөр	150000.00	45061.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	354900.00	198600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	354900.00	198600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10984900.00	10228800.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10984900.00	10228800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4984900.00	4984900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5500000.00	5243900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	683199600.00	683199600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	683199600.00	683199600.00
122005	Орон нутгийн төсвөөс	683199600.00	683199600.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	0.00
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1000000.00	1107549.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Бусдаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ		346504430
Түлш,шатахуун худалдан авсан		7360430
Төвлөрүүлэх шилжүүлэг		392130